

## ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

1. ГЛОБАЛЬ САН “СҮРЭЭГИЙН ТОХИОЛДЛЫГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ДАДЛЫГ ДЭМЖИХ ЗАМААР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, ӨВЧТӨН ТӨВТЭЙ НЭГДСЭН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГААГ БҮРДҮҮЛЖ ХЭВШҮҮЛЭХ, ЭМИЙН ДАСАЛТТАЙ СҮРЬЕЭГИЙН АЮУЛД АНХААРАХ” ТӨСӨЛ

<b>№</b>	<b>Төсөл агуулга</b>	<b>хөтөлбөрийн</b>				“Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж хэвшүүлэх, эмийн дасалттай сүрьеэгийн аюулд анхаарах”
1	Төсөл хөтөлбөрийн нэр: Огноо, шийдвэрийн дугаар:					ДОХ/Сүрьеэгийн төсөл
2	Санхүүгийн эх үүсвэр					НҮБ-Глобал сан
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Монгол улс ЭМЯ, Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг Орхон аймаг дахь салбар				
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМГ, БОЭТ, Өрхийн ЭМТ, Жаргалант сумын ЭМТ				
		Хэрэгжих хугацаа: 2021-2023 он				
4	Хариуцан ажиллаж буй албан тушаалтан					Б.Энхтуяа Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн Орхон аймаг хариуцсан төслийн ажилтан утас:86208188, enkheerdenet@yahoo.com
5	Төсөл хөтөлбөрийн зорилт					Зорилт1. Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. Зорилт 2. Олон эмэнд дасалтай сүрьеэг эрт илрүүлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх Зорилт3. Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, ялгаварлан гадуурхалтыг бууруулах Зорилт 4. Нийт хүн амд сүрьеэгийн чанартай тусламж үйлчилгээг тэгш хүргэх
6	Төслийн зардал	Үүнд	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Тайлбар
		Багц 1	Эмийн төсөв Глобал сан	26,564,603	100%	Жилдээ
		Багц 2	Буцалтгүй тусламж	11,760,000	100%	
		Багц 3	Гэрийн эмчилгээ	13,433,000	100%	
7	Төсөл хөтөлбөрийн зорилт					Хэрэгжилт

<p>8</p>	<p>Зорилт 1: Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.</p> <p>Хүрэх үр дүн: Сүрьеэгийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээний үр дүнг 90 хувьд хүргэж, нас баралтыг 2015 оны үзүүлэлтээс 30 хувиар бууруулна.</p>	<p>Тайлант хугацаанд сүрьеэгийн үзлэгт нийт 5231 хүн хамрагдсанаас 67,7% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Тайлант хугацаанд дижитал рентгенээр 14859 хүн цээжний зураг авахуулснаас 11887 буюу 81,0% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр хамрагдсан, GENE-xpert аппаратаар 2295 хүний 4590 сорьц шинжлэн уушгины халдвартай хэлбэрийн 20, уушгины бус эерэг 8 нийт 28 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд бүрэн хамруулсан.</p> <p>2021 оны 11-р сарын 18-наас Өрхийн Анагаах Ухааны Холбоотой хамтран Орхон аймгийн өрхийн эрүүл мэндийн төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв дээр сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 955 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж сүрьеэгийн нэг тохиолдол илрүүлж эмчилгээнд нь хамруулсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>Халдвартай болон олон эрхтэн хамарсан сүрьеэгийн хүнд хэлбэрээр эмчилгээ хяналтад орж буй хүмүүсийг сүрьеэгийн тасагт 100% хэвтүүлэн эмчилж хянаж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд 44 өвчтөн эмчлэгдэж хянагдаж байгаагаас тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 10 өвчтөн, сайн дурын ажилтнаар 22 өвчтөн, хоолтой эмчилгээнд 8 өвчтөн тус тус эмчлүүлж байна.</p> <p>Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 47 бүртгэгдэж, 10000 хүн амд 4,5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2,6 промиллоор буурсан байна.</p> <p>Сүрьеэгийн нас баралтын тохиолдол 3 бүртгэгдэж өнгөрсөн оноос 1 тохиолдлоор буурсан байна.</p>
<p>9</p>	<p>Зорилт 2: Олон эмэнд дасалтай сүрьеэг эрт илрүүлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх</p> <p>Хүрэх үр дүн: Олон эмэнд болон рифамицинд тэсвэртэй сүрьеэгийн</p>	<p>Тайлант хугацаанд эмэнд тэсвэртэй байж болзошгүй тохиолдлыг ялган оношлох шинжилгээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвд 40 сорьц хүргүүлсэн байна. Жаргалант сумын эрүүл мэндийн төвөөс 71 сорьц БОЭТ-ийн сүрьеэгийн лабораторит хүргүүлснээс 1 шинэ сүрьеэгийн тохиолдол, 1 дахисан тохиолдол илэрч эмчилгээнд орсон. Одоогийн байдлаар олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 9 хүн эмчилгээний хяналтад эмчлүүлж байгаагаас тайлант хугацаанд 4 хүн шинээр бүртгэгдэж эмчилгээнд орсон байна. Эмчилгээний амжилт 71,9% байна.</p>

	<p>тохиолдлын эмчилгээний үр дүн нэмэгдэнэ.</p>	
<p>10</p>	<p>3-р зорилт: Хүн амын сүрьеэгийн талаарх мэдлэг хандага, дадал өөрчлөгдсөн байна. Хүрэх үр дүн: Иргэдийн мэдлэг мэдээлэл сайжирсан байна.</p>	<p>Орхон аймгийн FM107,5 радиогоор Сүрьеэ диспансерийн эмч оролцож иргэдэд сүрьеэ өвчин Дэлхий дахинд болон Орхон аймгийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгч иргэдийн сонирхсон асуултад хариулт өгсөн. Цахим шууд дамжуулалтаар Номин ТВ-д мэдээлэл ярилцлага өгсөн ба мэдээллийг 3120 хүн үзэж хандсан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ирүүлсэн 5 төрлийн гарын авлага 1 бичлэгийг цахимд хуваарийн дагуу байршуулан иргэдэд хүргэсэн. Эрүүл мэндийн байгууллагуудаар сүрьеэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 38 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2513 иргэнийг хамруулан, 2293 ширхэг сургалт сурталчилгааны материал түгээсэн байна.</p>
<p>11</p>	<p>4-р зорилт Эмзэг бүлгийн бүлгийн хүн амд хүрэх сүрьеэгийн тусламж үйлчилгээ өргөжсөн байна.  Хүрэх үр дүн:</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын нээлттэй 427-р хорих ангийн албан хаагч болон хүмүүжигч 133 хүнээс сүрьеэгийн асуумж авч, цээжний рентген шинжилгээнд хамруулахад сүрьеэ илрээгүй. БОЭТ-өөс 4 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг эрчимжүүлж, нийт хавьтлын 98, эрсдэлт бүлгийн 320 хүнээс асуумж судалгаа, цээжний рентген зураг авч шинэ сүрьеэ 1 илрүүлж эмчилгээнд хамруулсан. Глобал сангийн санхүүжилтээр улирал бүр 24 хүнд, нийт 96 хүнд хүнсний тусламжийг олгосон.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>

Орхон аймгийн хэмжээнд МСТН-ийн 15 сайн дурын ажилтан ажилласан. Сүрьеэгийн диспансерт бүртгэгдсэн өвчлөлийн 65,6%-ийг бэлтгэгдсэн сайн дурын ажилтны хяналтад хамруулан эмийг нь гэрээр нь харж уулгаснаар эмчилгээний тасалдал үүсээгүй. Сайн дурын ажилтны унааны зардалд сар бүр 40\$ олгосон.



12 Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)

Ололттой тал:

- Үйлчлэх хүрээний хүн амд ноогдох эмчийн тоог нэмж, диспансерийн халдвар хяналтын тогтолцоог сайжруулах үүднээс амбулаторийн эмчийн тоог 1 ээр нэмэгдүүлж, кабинетыг мөн нэмэгдүүлсэн.
- Глобаль сангийн санхүүжилтээр 20121онд 51.6 сая төгрөгийн өртөг бүхий амьсгалын аппаратаар хангаж тусламж үйлчилгээг нэмэгдүүлж.

Дутагдалтай тал:

- Хүн амын амьдралын түвшин дорой, хотжилт төвлөрөлт нэмэгдэж, хүн амын шилжилт хөдөлгөөн их, улирлын чанартай ажил хийх байдал их, орчны бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө ихсэж буй нь өвчлөл буурахгүй, эдгэрэлт удаашрах, хүндрэл үүсэхэд нөлөөлж байна.

**Тулгамдаж буй асуудал:**

- Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд улсын төсөв, орон нутгийн төсвөөс оношилгоо болон эмчилгээний зардалд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байна.
- Диспансерийн халдвар хяналтын тогтолцоо бэхжээгүй байна.
- Салбарын байгууллагын оролцоо сул, уялдаа холбоог сайжруулах шаардлага байна.

13 Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ

- Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд төрийн байгууллагуудын оролцоо сул, төрөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээ нэмэгдэхгүй байна.
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын оролцоо сул байна.

Төсөл

Биелэлт

Зорилтын тоо

Зорилт 1

Зорилт 2

Зорилт 3

Зорилт4

14	хөтөлбөрийг хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	дундаж					
		100 %	2	100%	70%	70	100
15	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ 85%					

2. ЖАЙКА ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА “АНХАН БОЛОН ХОЁРДОХ ШАТЛАЛЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

№	Төсөл хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл				
1	Төсөл хөтөлбөрийн нэр: Огноо, шийдвэрийн дугаар:	Анхан болон хоёрдох шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 10-р сарын 18-ны өдрийн 2 дугаар тогтоол				
2	Санхүүгийн эх үүсвэр	“Жайка” Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламж				
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Бүсийн оношилгоо эмчилгээний төв Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, ЭМХТ, Орхон аймгийн ЗДТГ, ЭМГ, Сургалт эрхлэх сүлжээ эмнэлгүүд /Медипас эмнэлэг, Мэндцэцэн, Үйлсбадрах ӨЭМТ, Жаргалант СЭМТ/ Хэрэгжих хугацаа: 2015-2020 он				
4	Төсөл хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Сургалт зохион байгуулах, хянах чадавхыг сайжруулах Зорилт 2. Сургалтын хөтөлбөр боловсруулах Зорилт 3. Орон нутагт сургалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх				
5	Зардал	Төсөв	Нийт 48.0 сая төгрөг			
		Үүнд:	Төсөв (2018 он)	Гүйцэтгэл	Хувь	Тайлбар
		Багц 1	Орон нутаг	40.0 сая	100%	Сургалтын тоног төхөөрөмж, эд материал
		Багц 2	Жайка Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага	8,0 сая	100%	Сургалтын компьютер, прентир
	Төсөл хөтөлбөрийн зорилт	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.				
	Зорилтын 1 Хүрэх үр дүн: ЭМЯ болон ЭМХТ-н төгсөлтийн дараах сургалтын	Энэ төсөл нь Монгол Улсын ЭМЯ-наас ЖАЙКА ОУ-ын байгууллагад тавьсан хүсэлтийн дагуу 2015 оноос үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн. Орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх үндсэн				

<p>удирдлага, зохион байгуулалтын чадвахи сайжирна.</p>	<p>зорилготойгоор ЭМЯ болон ЭМХТ-тэй хамтран хүний их эмчийн төгсөлтийн дараахь сургалтын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэн ажилласан. Тухайлбал, Монгол Улсын орон нутагт ажиллах чадвар бүхий эмчийг бэлтгэхийн тулд төгсөлтийн дараахь сургалтын хөтөлбөр боловсруулсан.</p> <p><b>Сургалт зохион байгуулах, хянах чадавхыг сайжруулах:</b>  2016 онд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 тоот тушаалд заагдсанаар хүний их эмч нь төгсөлтийн дараахь үндсэн мэргэшлийн сургалтын нэг жилийг Ерөнхий мэргэшил судлал сургалтад суралцах болсон. Үүнтэй холбоотой шинээр сургалт эрхлэх эмнэлгүүдийг бэлтгэж, суралцагч эмчийг сургах хэрэгцээ бий болсон. Иймээс уг төслийн хүрээнд Япон Улсын төгсөлтийн дараахь сургалтын тогтолцоонд үндэслэн, Монгол Улсад төгсөлтийн дараахь сургалтыг үр дүнтэй сайжруулахын тулд ЭМЯ болон ЭМХТ-тэй хамтран, төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх шалгуур, суралцагч эмчийн үнэлгээний аргачлалыг сайжруулах зэрэг үйл ажиллагааг явуулсан.</p>
<p>Зорилтын 2  Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын хөтөлбөр боловсронгуй болно.</p>	<p>Сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх:  <u>Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалт:</u> Япон Улсын “Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам”-ны удирдамжийн дагуу зохион байгуулагддаг сургагч багшийн сургалтын агуулгад үндэслэн Монгол Улсын сургагч багшийг бэлтгэх ТОТ сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Уг ТОТ сургалтыг явуулах, зохион байгуулах чиглүүлэгч багш нарыг мөн сургаж бэлтгэсэн.</p> <p>Орхон аймгийн хувьд ТОТ – эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг ЭМЯ, ЭМХТ, ЖАЙКА төслийн багтай хамтран нийт 6 удаа зохион байгуулж, БОЭТ-ийн 41 эмч, сүлжээ эмнэлгийн 15 эмч бэлтгэгдэн эмнэлзүйн сургалт удирдан явуулах бүрэн боломжтой болсон.</p> <p>Эмнэлзүйн сургагч багш нарын 85.7% нь мэргэжлийн болон эрдэмийн зэрэг цолтой багш нар эзлэдэг бөгөөд үүнээс ахлах зэрэгтэй 18, тэргүүлэх зэрэгтэй 14, АУ-ны магистр 21, АУ-ны доктор эрдэмтэн багш нараар багаар бүрдүүлсэн.</p>





*Зураг 1, 2 БОЭТ-ийн үндэсний чиглүүлэгч багш нарын анх удаа бие даан удирдсан TOT сургалт*

Төгсөлтийн дараах сургалт эхлэхээс өмнө Монгол Улсын сургалт эрхлэх эмнэлгийн эмч нараас Япон Улсын эмнэлэгт явагддаг төгсөлтийн дараах сургалтын явцтай танилцаж, сургалтын давуу тал болоод хэрэгжүүлбэл зохих зүйлийн талаар суралцаж, одоогийн сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Орхон аймгаас 5 удаа 7 эмч нар тус Япон дахь сургалтад хамрагдсан.



*Зураг 3, 4. Япон Улсын төгсөлтийн дараах сургалт  
Ерөнхий мэргэшил судлалын сургалтын хөтөлбөр боловсруулах:*

Дэлхийн чиг хандлагыг даган, чадамжид суурилсан хөтөлбөрийн загварыг үндэслэн Монгол Улсын орон нутагт ажиллах чадвар бүхий ерөнхий мэргэшлийн эмчийн эзэмших шаардлагатай чадамжийг (competency) олгох хөтөлбөрийг боловсруулж ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр батлуулж батлагдсан хөтөлбөрийн дагуу Монгол улсад анх удаа Орхон аймгийн БОЭТ нь сургалтын эмнэлгийн зөвшөөрөлтэйгээр 2018 оны 10 сараас Ерөнхий мэргэшил судлалын сургалтыг загвар болгон зохион байгуулж эхэлсэн.

Тасралтгүй сургалтын багцыг боловсруулах:

Төслийн хүрээнд Эмч нарын тасралтгүй сургалтын багцыг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Японы мэргэжилтний зааварчилгаагаар Яаралтай тусламжийн сургалтын багцыг боловсруулж, сургалтыг монгол эмч нар удирдан зохион байгуулсан. Түүнчлэн эмнэлгийн мэргэжилтний халдварын сэргийлэлт, яаралтай тусламж, хүүхдийн өвчин судлал, ёс зүйн сургалтуудыг тус тус зохион байгуулан хамтран ажиллалаа. Төслийн хүрээнд яаралтай тусламж, хүүхэд, хүүхдийн яаралтай тусламж, гэмтэл, халдварт өвчний сургалтыг 13 удаа явуулж, 280 эмч суралцсан.



*Зураг 7, 8, 9. Тасралтгүй сургалт*

**Зорилт 3**

Хүрэх үр дүн: Загвар аймгийн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын систем тогтвортой болно.

Жайка ЯОУХАБ-ын төслийн дэмжлэгээр Монгол улсад анх удаа ерөнхий мэргэшлийн эмч нарын төгсөлтийн дараах сургалтыг Орхон аймгийн БОЭТ эхлүүлсэнтэй холбогдуулан сургалтыг шууд удирдан явуулах эмч-эмнэлзүйн сургагч багш нар Япон улсын зөвлөх багш нартай хамтран тойролт тус бүрд хэрэглэгдэх резидент эмч нарт зориулсан “Хүүхэд судлалын тойролт”, “Эх барих эмэгтэйчүүд судлалын тойролт”-ын өврийн номыг боловсруулж, ЭМЯ-ны харьяа салбар мэргэжлийн зөвлөлүүдээр тус тус батлуулан сургалтанд хэрэглэж байна. Мөн сургалтын хөтөлбөрт тусгагдсан зайлшгүй суралцах 11 гардан үйлдэлийг сонгон авч Монгол улс болон олон улсын стандартад нийцсэн видео хичээл бүхий гарын авлагын хамт боловсруулсан.





*Зураг 10. Хүүхдийн судлалын тойролтын гарын авлагыг боловсруулсан ажлын хэсэг  
Зураг 11. Эх барих эмэгтэйчүүд судлалын тойролтын гарын авлагыг боловсруулсан ажлын хэсэг*



*Зураг 12,13. Төгсөлтийн дараах хөтөлбөрт тусгагдсан зайлшгүй суралцах гардан үйлдлийн гарын авлага болон видео боловруулах ажлын хэсэг*

БОЭТ-ийн дэргэд 11 хүний бүрэлдэхүүнтэй “Төгсөлтийн дараах сургалтын хяналтын зөвлөл” ажиллаж, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө, боловсруулах, тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт тусгагдсан зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоо, эмнэл зүйн тохиолдлын хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний журнал клубд оролцосон оролцоо зэргийг тойролт тус бүрт тойролт хариуцсан эмнэлзүйн сургагч багш нар үнэлгээг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулж тухайн тойролтыг төгсөлтийн эцсийн шийдвэр дүгнэлтийг гарган ажилласан. Мөн эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

зэргээр өнгөрсөн болон энэ хичээлийн жилд нийт 15 удаа хуралдаж, сургалттай холбоотой 52 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.



*Зураг 14, 15 Сургалтын хяналтын зөвлөлийн хурал*

- 2018-2019 оны хичээлийн жилд “Ерөнхий мэргэшил судлал”-ын анхны 4 резидент эмч,
- 2019-2020 оны 2 дах жилийн сургалтанд 5 резидент нар сургалтаа амжилттай төгссөн.
- 2020 оны 11 сараас БОЭТ нь Ерөнхий мэргэшил судлалын 3 дах жилийн сургалтад 3 резидент эмчийг элсүүлэн сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж байна.



*Зураг 16. Ерөнхий мэргэшил судлалын Төгсөлтийн арга хэмжээ ЭМХТ болон БОЭТ*

ЭМЯ нь ерөнхий мэргэшил судлалын сургалт эрхлэх эмнэлгүүдийг үе шаттай нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд чанартай тасралтгүй сургалт явуулах чадвартай эмнэлгүүдийг нэмэгдүүлэхийн тулд эмнэлгүүд хоорондоо бие биенээсээ суралцах холбоо харилцааг бүрдүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна. Иймээс Орхон БОЭТ нь орон нутгийн сургалт эрхлэх эмнэлгүүдийн жишиг буюу сургалтын туршлага судлах бааз эмнэлэг болсон.

- Бусад эмнэлгийн сургалтын албаны мэргэжилтнүүдэд зориулсан Ховд, Өвөрхангай, Өмнөговь болон Дорнод аймгийн БОЭТ, мөн Нийслэлийн хоёр дүүргийн эмнэлгийн сургалт хариуцсан мэргэжилтнүүд оролцож 2019 оны 6-р сарын 27, 28-ны өдрүүдэд туршилга солилцсон.
- Чингэлтэй ЭМТ-ийн сургалтын албаны 2 мэргэжилтэн (2019.04.08-04.10) Орхон БОЭТ-д Ерөнхий мэргэшил судлал сургалтын зохион байгуулалт, Сургалтын Хяналтын зөвлөл болон өглөөний конференцийг явуулах арга зүй зэрэгтэй танилцсан.



*Зураг 18. Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн Сургалтын албаны хамт*

*Зураг 19. Ховд, Өвөрхангай, Өмнөговь болон Дорнод аймгийн БОЭТ, мөн Нийслэлийн хоёр дүүргийн эмнэлгийн сургалт хариуцсан мэргэжилтнүүдийн хамт*

Түүнчлэн Төслийн багийн зүгээс Монголд анх удаа сувилагч нарт зориулсан сургагч багш бэлтгэх сургалт явуулахад чиглүүлж, дэмжлэг үзүүлэн ажилласан. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн яамны хүсэлтийн дагуу 2019 оны 6 сараас сувилагч нарын сургагч багш бэлтгэх сургалт явуулах бэлтгэхээр ЭМЯ-ны дэргэд ажлын хэсэг байгуулагдаж үйл ажиллагааг явуулж эхэлсэн.


Сургалтын хугацаанд хийгдсэн үнэлгээ:

ЭМЯ болон ЭМХТ-ийн үнэлгээ

ЭМЯ, ЭМХТ-өөс Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх Сургалт эрхэлэх байгууллагын зөвшөөрөл хүсэхтэй холбоотой бэлтгэл ажлын явцтай танилцах, дэмжлэгт хяналтыг 2017, 2018 онуудад тус тус хийгдсэн. 2018 оны 10 сараас эхлэн явагдаж буй Ерөнхий мэргэшил судлалын сургалтын хэрэгжилтийн талаарх үнэлгээг 2019 оны 6 сард Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн мэргэжилтэн ирж үнэлгээг хийлээ. Үнэлгээ нь сургалтын зохион байгуулалт, хяналтын тогтолцоо, сургалтын орчин (сургалтын өрөө, тоног төхөөрөмж), суралцагч эмчийг дэмжих орчин, сурган заах бүтэц, хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай, суралцагч эмчийн үнэлгээ зүй зохистой хийгдэж байгаа эсэх зэрэг нийт 60 гаруй шалгуураар



хийгдэж, БОЭТ нь улсын хэмжээнд сургалт эрхэлж буй эмнэлгүүдээс хангалттай сайн түвшинд үнэлэгдлээ.




Зураг 20. ЭМХТ-ийн үнэлгээ /2019.06.27/ Зураг 21. ЭМЯ болон ЭМХТ-ийн үнэлгээ /2018. 07. 26/ “Жайка” төв Азийн олон улсын үнэлгээний багийн үнэлгээ:

“Жайка” төв Азийн олон улсын үнэлгээний багийн мэргэжилтнүүд Орхон аймгийн БОЭТ-д нийт 3 удаа хүрэлцэн ирж (2017, 2019 оны 3, 10 сар) ирж, төгсөлтийн дараах сургалт хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажил болон сургалтын явцын үнэлгээг тус тус хийж төслийн явцыг хангалттай гэж үнэллээ.

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Орхон БОЭТ нь орон нутгийн сургалт эрхлэх эмнэлгүүдийн жишиг буюу сургалтын туршлага судлах бааз эмнэлэг болсон. Орхон аймгийн хувьд ТОТ – эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг ЭМЯ, ЭМХТ, ЖАЙКА төслийн багтай хамтран нийт 6 удаа зохион байгуулж, БОЭТ-ийн 41 эмч, сүлжээ эмнэлгийн 15 эмч бэлтгэгдэн эмнэлзүйн сургалт удирдан явуулах бүрэн боломжтой болсон. 4 эмч төгсөж, 5 эмч суралцаж байна. 2020 оны 11 сараас БОЭТ нь Ерөнхий мэргэшил судлалын 3 дах жилийн сургалтад 3 резидент эмчийг элсүүлэн сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж байна.				
8	Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	ЭМЯ, ЭМХТ, Жайка төв Азийн олон улсын үнэлгээгээр хангалттай сайн үнэлэгдсэн.				
9	Төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 100%	Зорилтын тоо 3	Зорилт1 100%	Зорилт 2 100%	Зорилт 3 100%
10	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ 100%				

3. ЛЮКСЕМБУРГИЙН ВАНТ УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ “ЗҮРХ СУДАСНЫ ТӨВ, ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨРГӨЖИЛ” ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Төсөл хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл хөтөлбөрийн нэр: Огноо, шийдвэрийн дугаар:	“Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил МОН/005” төсөл нь Монгол улсад Люксембургийн вант улсын буцалтгүй тусламжаар 2001 оноос хэрэгжсэн “Зүрх судасны төв” төслийн үргэлжлэл 3-р шат бөгөөд нэг, хоёрдугаар шатны төслүүдийн ололт амжилт дээр суурилсан төсөл.			
2	Санхүүгийн эх үүсвэр	Люксембургийн Их Гүнт Улс: Монгол Улс: 3 сая евро			
3	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Бүсийн оношилгоо эмчилгээний төв			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Люксембургийн вант улсын Хөгжлийн агентлаг			
		Хэрэгжих хугацаа: 2005-2020 он			
4	Хариуцан ажиллаж буй албан тушаалтан	БОЭТ-ийн Поликлиникийн Зүрх судасны кабинетын эмч М.Ундрах			
5	Төсөл хөтөлбөрийн зорилт	Зорилт 1: төслийн 1-р бүрэлдэхүүн хэсэг: Телемедицин Хүрэх үр дүн: Үндэсний цахим эрүүл мэндийн стратегийн хэрэгжилтийг нэмэгдүүлнэ. Зорилт 2: төслийн 3-р бүрэлдэхүүн хэсэг: Зүрхний эмгэг судлал			
6	Зардал	Төсөв	Нийт төсөв		
		Үүнд:	<b>2021 онд</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Тайлбар</b>
		Багц 1	Тоног төхөөрөмж /15,115,300/	3,105,300 төгрөг	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат
				3,100,000 төгрөг	Артерийн даралт хэмжих автомат аппарат
				880,000 төгрөг	Орон зайг уураар ариутгагч
Багц 2	Сургалт	-	Иммунологийн шинжилгээний анализатор		
8	Төсөл хөтөлбөрийн зорилт	Хэрэгжилт			
	Зорилт 1. Телемедицин	Телемедицин ба Зүрх судасны МОН005 төслийн хүрээнд цахим өвчний түүхээр онош эмчилгээний зөвлөгөө авах шаардлагатай 21 хүний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Төсөл хэрэгжих хугацаанд 91 удаагийн хэлэлцүүлэгт оролцсон. Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 2192 хүний мэдээллийг оруулсан. Зүрх судасны эмч нар цахимд байрлуулсан мэргэжлийн зайн сургалтанд тогтмол хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлж, багц цаг бүрдүүлсэн. MnCardio программын сургалт, шинэчлэгдэн батлагдсан заавар удирдамжуудыг хэрэгжүүлэх сургалтыг Судасны багаас хийж, титэм судсан дотуурхи эмчилгээний дараахь, зүрхний шигдээсийн дараахь хяналтын үзлэг, зүрхний эхо, зүрхний ишемитэй судсан дотуурхи оношилгоо эмчилгээ шийдүүлэх, захын судасны			

		<p>эмгэгтэй хүмүүст үзлэг хийн зөвлөгөө өгч шийдвэрлэсэн. Улсын клиникийн гуравдугаар эмнэлгийн Зүрх судасны төвөөс Пүрэв гараг бүр зохиож байгаа Zoom Online сургалтад эмч нар хамрагдаж, мэдлэгийг дээшлүүлсэн.</p> 
7	Зорилт 2. Зүрхний эмгэг судлал	<p>Тайлант хугацаанд зүрхний цахилгаан бичлэг 8142, 24 цагийн холтер зүрхний цахилгаан бичлэг 115, 24 цагийн артерийн даралт хэмжигч 11, Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг 21 хийгдсэн. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Холтер ЗЦБ 115 хүнд хийснээс далд хэм алдагдал 51 ишеми 17,</li> <li>- Ачаалалтай ЗЦБ 21 хүнд хийснээс далд ишеми 11 оношилж эмчилсэн.</li> <li>- 24 цагийн даралт хэмжих аппаратаар 11 хүнд үйлчилж хоногийн даралтны түвшинг тогтоон, эмийн тун, эмчилгээний үр дүнг тогтоосон.</li> </ul> <p>Зүрхний ЭХО шинжилгээгээр ховор тохиолдол зүрхний хоргүй хавдар 2-ыг шинээр оношилж хагалгаа хийлгэсэн, Нярай хүүхдийн төрөлхийн хавсарсан гажиг судасны эмгэг 12, зүрхний зүүн ховдолын гипоплази 1 тус тус оношилсон.</p> <p>Дээд шатлалын эмнэлэгт зүрхний олдмол гажиг 5, төрөлхийн гажигтай 115 хүн зэрэг нийт 160 хүнийг илгээсэн. Зүрхний ишеми, инфаркттай 21 хүнийг оновчтой цаг хугацаанд нь коронарангиографийн шинжилгээнд илгээж, судсан дотуурх эмчилгээг хийлгэсэн. Төрөлхийн гажигтай 5 хүнийг хагалгаа олдмол гажигтай 2 хүнийг хавхлага солих хагалгаанд тус тус оруулсан.</p> <p>Зүрх судасны өвчлөлийн тэргүүлэх байранд артерийн даралт ихсэх өвчин, зүрхний ишеми, зүрхний олдмол гажиг, зүрхний төрөлхийн гажиг, системийн өвчнүүд орж байна. Диспансерийн хяналтад 243 өвчтөн байна.</p>
	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололттой тал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оношилгооны шинэ багаж тоног төхөөрөмжөөр хангагдсанаар эмчилгээ, оношлогооны чанарт дэвшил гарсан. Тухайлбал зүрхний хэт авиан шинжилгээгээр нярайн хавсарсан хүнд гажигууд болон констриктив перикардит, аортын аневризм, бактериальны</li> </ul>



		<p>эндокардит, тромбо миксома зэрэг ховор тохиолдлуудыг амжилттай оношилж 625 хүний эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Мөн холтер 3ЦБ, ачаалалтай 3ЦБ, холтер даралт хэмжих аппаратуудаар зүрхний хэм алдагдал, далд ишемийг илрүүлэн оношлогоо, эмчилгээнд ахиц гаргалаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээд шатлалын эмнэлэгт оновчтой шилжүүлэг нэмэгдэж, үр дүн нь сайжирсан. Зүрхний ишеми, инфаркттай 21 хүнийг оновчтой цаг хугацаанд нь коронарангиографийн шинжилгээнд илгээж, судсан дотуурх эмчилгээг хийлгэсэн. Төрөлхийн гажигтай 5 хүнийг хагалгаа хийлгэсэн. Олдмол гажигтай 2 хүнийг хавхлага солих хагалгаанд оруулсан. Мөн хэм алдагдлын хүнд хэлбэртэй өвчтөнд пейсмекер эмчилгээ, захын судасны бөглөрөлтэй хүнд эрсдэлтэй өвчтөнг цаг хугацаанд нь илгээж судасны мэс засал хийлгэж эмчилгээний үр дүн сайн байна.</li> </ul> <p>Дутагдалтай тал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутагт зүрх судасны мэргэшсэн эмч боловсон хүчний нөөц дутагдалтай, дотрын нарийн мэргэжлийн резидент төгссөн цаашид зүрх судасны чиглэлээр мэргэших сонирхолтой эмчийг зүрх судасны кабинетад ажиллуулж байна.</li> <li>- 2018 оны 11 сард суурилуулсан Philips affinity 70 зүрхний өнгөт хэт авиан шинжилгээний хариуг үйлчлүүлэгчдэд хэвлэж өгөх EPSON 550 маркын өнгөт принтер, улаан хоолойн ЭХО - ны датчик зэрэг дутагдалтай байна.</li> </ul>			
8	Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн талаас зүрх судасны оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийг суурилуулан эзэмшүүлж, мэргэжлийн сургалт олон улсын хурал семинар зохион байгуулах, вэб хуудсаар дамжуулан зайн сургалтад хамруулах, гадаадад богино хугацаагаар сургах мэргэшүүлэх, теле-зөвөлгөө өгөх			
9	Төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт1	Зорилт 2
		100%	2	100%	100%
10	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ			
		100%			

4. ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА “КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ОРХОН АЙМГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Төсөл хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл хөтөлбөрийн нэр: Огноо, шийдвэрийн дугаар:	КОВИД-19 цар тахлын эсрэг орхон аймгийн хариу арга чадавхийг бэхжүүлэх төсөл 2021 оны 08 дугаар 02-ны өдрийн № хамтран ажиллах гэрээ			
2	Санхүүгийн эх үүсвэр	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага: 141,321,300 сая төгрөг			
3	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Эрүүл мэндийн газар			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ДЭМБ			
		Хэрэгжих хугацаа: 2021 оны 08.02-2021.12.31 хооронд			
4	Хариуцан ажиллаж буй албан тушаалтан	Эрүүл мэндийн газрын дарга Д.Сүхээ			
5	Төсөл хөтөлбөрийн зорилт	Зорилт 1. КОВИД-19 цар тахлын үеийн салбар хоорондын хамтын ажиллагаа, тохиолдлын удирдлагын тогтолцоог дэмжих, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх			
6		Төсөв	Нийт төсөв		
		Үүнд:	2021 онд	Гүйцэтгэл	Тайлбар
		Багц 1	Сургалт	11,339,200	100%
		Багц 2	Тандалт судалгаа	112,450,000	100%
		Багц 3	Хяналт	5,415,000	100%
		Багц 4	Бусад	6,051,100	100%
7	Төсөл хөтөлбөрийн зорилт	Хэрэгжилт			

Зорилт 1.

1. Дүн шинжилгээнд суурилсан мэдээллээр шийдвэр гаргагч нарыг хангаж шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй, оновчтой хэрэгжүүлж халдварын тархалтыг бууруулна

2. Эмнэлгийн бус байр/хээрийн эмнэлэг дэлгэснээр батлагдсан тохиолдлыг эрт тусгаарлан халдварын тархалтыг бууруулж хүндрэл, нас баралтаас сэргийлнэ

3. Орон нутгийн салбар хоорондын үнэлгээнд үндэслэн хариу арга хэмжээний шинэчилсэн төлөвлөгөө, зааврыг шинэчлэн батлуулна

4. Дотоодын хяналт, үнэлгээ тогтмолжиж анхан шатны эрүүл мэндийн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ

1. Төслийн хүрээнд 6 удаагийн сургалтыг зохион байгуулж 212 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжсан. Үүнд:

- Хавьтлын судалгаа, кластерын судалгаа, мэдээлэл дүн шинжилгээ хийх чиглэлээр сургалтад 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж тандалт судалгааны багаа өргөжүүлэн хавьтал, кластер өвчлөлийн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх чадавх бүхий баг бүрдсэн.

- Хавьтал тандалтын судалгаанд 34 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон. Дайчлан ажилласан хүний нөөцийг сургах сургалтад 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж чадавхжуулсан, шуурхай хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй болсон. Чадавх бүхий баг бүрдэж 100% хариу арга хэмжээнд дайчлагдан ажилласан.


- Эмнэлзүйн чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн 120 буюу нийт эмч, мэргэжилтнүүдийн 17,1% нь дээрх сургалтад хамрагдаж чадавхжсан. Халдвар авсан иргэдийг зөв эрэмблэж хүндрэлээс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх үнэлгээг хийх, коронавируст (КОВИД-19)-ын халдварын үеийн эмчилгээ, оношилгоо, яаралтай тусламжийн чиглэлээр дайчлан ажиллуулснаар ковидын шалтгаант хүндрэл, нас баралт буурсан. Тухайлбал ковидын шалтгаант 49 нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 9 сард 14, 10 сард 14, 11 сард 1, 12 сард 2 байна.



2. Идэвхтэй 55 кластер өвчлөлөөс өвөрмөц 5 кластер багц өвчлөлийн 1832 халдварын тохиолдлын голомтыг судлан халдварын цар хүрээ, хавьтал кластер өвчлөлийн мэдээллийг нягтлан дүн шинжилгээ хийж шийдвэр гаргагч нарыг нотолгоонд суурилсан мэдээллээр ханган, халдварын голомтыг хумих цомхотгох арга хэмжээг хэрэгжүүлж, шаардлагатай санхүүжилтийг орон нутгаас шийдвэрлүүлж ажилласан.



Халдварын гинжин хэлхээ



3.

Коронавируст/КОВИД-19/халдварын үеийн орон нутгийн салбар хоорондын хамтын ажиллагаа, хариу арга хэмжээнд хийсэн явцын үнэлгээнд төрийн байгууллагууд болон БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, тусгаарлах эмнэлэг зэрэг нийт 37 байгууллагын 72 ажилтныг хамруулсан. Салбар хоорондын болон үнэлгээний багийн уулзалтыг зохион байгуулж, Коронавируст/КОВИД-19/халдварын үеийн орон нутгийн салбар хоорондын хамтын ажиллагаа, хариу арга хэмжээнд хийсэн явцын үнэлгээний дүн танилцуулагдаж, хариу арга хэмжээний үр дүн, сайн туршлага, бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлж, саналыг багцалсан. Коронавируст халдварын цартахлын хариу арга хэмжээний шинэчилсэн төлөвлөгөөг ЭМГ-ын даргаар батлуулсан. Дотоодын хяналт үнэлгээг Жаргалант сумын Шуурхай штаб, Эрүүл мэндийн төв дээр ажиллаж, хариу арга хэмжээнд явцын үнэлгээг зохион байгуулж үнэлгээний дүнд өнөөгийн түвшинг тодорхойлогдож, 4 чиглэлээр 21 зөвлөмжийг өгч ажилласан ба сумын хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийгдсэн.



9	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст /КОВИД-19/ халдварын үеийн орон нутгийн салбар хоорондын хамтын ажиллагаа, хариу арга хэмжээнд явцын үнэлгээ хийж хариу арга хэмжээний үр дүн бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээнд суурилсан мэдээллээр шийдвэр гаргагч нарыг хангаж шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй, оновчтой хэрэгжүүлснээр халдварын тархалт буурсан, гэрийн нас баралт бүртгэгдээгүй.</li> <li>- Хавьтлын судалгаа, кластер өвчлөлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж шийдвэр гаргагч нарыг нотолгоонд суурилсан мэдээллээр ханган, халдварын голомтыг хумих цомхотгох арга хэмжээг эрчимжүүлэн, хариу арга хэмжээний чадавх бэхэжсэн.</li> <li>- Төсөл хэрэгжих үед аймгийн хэмжээнд КОВИД-19-т зориулсан эмнэлгийн ор 400, эрчимт эмчилгээний ор 10, 5 тусгаарлах байранд 300 ор ажиллаж байсан бол эрчимт эмчилгээний 20 ор, эмнэлгийн бус байранд /МСҮТ, Эрдэнэт зочид буудал/ нэмэлтээр ор дэлгэн нийт 760 ороор ажиллан, тусламж үйлчилгээний ачааллыг бууруулж, хүндрэл, нас баралтаас сэргийлж ажилласан.</li> <li>- Эмч мэргэжилтнүүд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тандах, эрт илрүүлэх, эрэмбэлэн ангилах, эрт сэрэмжүүлэх үнэлгээ, нэн шаардлагатай тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх чиглэлийн мэдээлэл, аргазүй дутмаг, шуурхай хариу арга хэмжээ авах мэдлэг чадвар хангалтгүй байсан бол эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилт сайжирч, эмч нарын ур чадвар нэмэгдсэн.</li> <li>- Дайчлан ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж, чадавх бүхий багийг бүрдүүлсэн Орон нутгийн хариу арга хэмжээний явцыг хянах, үнэлэх үйл ажиллагаа хийгдээгүй байсан. Төслийн үр дүнд явцын үнэлгээ, дотоод хяналт хийгдэж, хариу арга хэмжээний төлөвлөлт гүйцэтгэл сайжирсан.</li> <li>- Шинэ сайн туршлагуудыг танилцуулан, сурталчилсан.</li> <li>- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээний шинэчилсэн төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг эрэмбэлэн, хариу арга хэмжээний шинэчилсэн төлөвлөгөөг батлуулсан.</li> <li>- Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан.</li> </ul>
10	Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Салбар хоорондын оролцоо сайн байсан.
11	Төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Зорилт 1 100
12	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ 100%